

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДАРГЫГ
ЧӨЛӨӨЛӨХ, ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.3 заалт,
Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:

- Компанийн 2024 оны 10-р сарын 19-ний ээлжит бус хурлыг удирдан зохион
байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн дарга Ч.Чинзоригийг чөлөөлж, ТУЗ-
ийн гишүүн Ч.Тэмүдэрийг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.Чинзориг



**ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨХ
НӨХЦӨЛ, ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх “Зээлийн бүтээгдэхүүний нөхцөл”-ийг хавсралт 1-р баталсугай.
2. Компанийн “Зээлийн үйл ажиллагааны журам”-ыг Хавсралт 2, “Зээлийн гэрээ”-г Хавсралт 3, Фидукийн гэрээг Хавсралт 4, Барьцааны гэрээг Хавсралт 5, Нэмэлт гэрээг Хавсралт 6-р тус тус баталсугай.
3. Компанийн зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх “Зээлийн бүтээгдэхүүний нөхцөл”, “Зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх журам”, холбогдох гэрээг 2024 оны 10-р сарын 15-ны өдрөөс тус тус мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэг, Салбарын захирал Ц.Билэг-Өрнөхөд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

